

**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ
КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2019 оны 03 дугаар сарын
22-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ

ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1 дэх заалтууд, Санхүүгийн Зохицуулах хорооны “хувьцаат компанийн хурлын зар хүргэх хяналт тавих журам”, “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” нээлттэй хувьцаат компанийн дүрмийн 7.3, 7.43.3 дах заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14.00 цагт Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Самбуугийн гудамж, Орон зай төв 701 тоот зааланд хуралдуулахаар тогтоосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар доор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай.
 1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
 2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
 3. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай
 4. Компанийн стратегийн үйл ажиллагааны талаар мэдээлэл
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоосугай.
4. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд хавсралт №1, “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг хавсралт №2, “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийг хавсралт №3, “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал авах хуудсыг хавсралт №4-өөр тус тус баталсугай.

5. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14,00 цагаар тасалбар болгосугай.

6. Хурлын үед ажиллах тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- М.Отгонбаатар дарга
- Ч.Чинбат гишүүн
- Ш.Нарангаравуу гишүүн

Ээлжит хурлын санал авах үйл явцтай холбогдол бүхий бичиг баримтуудыг боловсруулах, баталгаажуулах, санал авах үйл явцыг зохих журмын дагуу зохион байгуулахыг тооллогын комисс /М.Отгонбаатар/-т даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар гүйцэтгэх захирал Н.Алтансүх, гишүүдээр хүний нөөцийн менежер Б.Отгонцацрал, ТУЗ-ийн гишүүн Д.Орхон нарыг тус тус томилсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар ТУЗ-ийн дарга Ж.Жаргалсайхан, тэргүүлэгчээр ТУЗ-ийн гишүүн Л. Ариунаа нарыг тус тус томилсугай.

9. Хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг гаргахыг компанийн санхүү /Ч.Чинбат/-д даалгасугай

10. Ээлжит хурлын зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслэл, радио телевизээр 2019 оны 03-р сарын 15-ны өдөр , давтамж зарыг 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдөр мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргэж хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх, танилцуулга бэлтгэх, хурлаас гарах шийдвэрийн төслийг бэлтгэх, хурлаас гарсан шийдвэр, бичиг баримтуудыг холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь хүргэх, энэ асуудалтай холбоотой бусад журмын заалтуудыг хэрэгжүүлэхийг комиссын дарга Н.Алтансүх /ажлын алба/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН